

АРЬСНЫ ӨВЧНИЙ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА

И.Дүүмаам¹, Д.Дунээрдорж², Л.Хүрэлбаатар³

¹*Алтантэмэлмийн ХХК.*

²*ЭМШУИС*

³*Монос анагаах ухааны дээд сургууль*

E-mail: altan_melmii@yahoo.com

STUDY OF MEDICINES USED FOR SKIN DISEASES

I.Duumaaam¹, L.Khurelbaatar², D.Dungerdorj³

¹*Altanmelmii Co.Ltd,*

²*Monos Medical University*

³*Health Sciences University of Mongolia*

Introduction

One of the main issues on the National drug policies in countries of the world and in Mongolia is the proper usage of the drug. In this frame, we need to study and to implement the methodical basis to use drug market drug marketing theoretical principles. They are: to improve and to follow new standard in diagnostics and diseases treatments prevailing in our country, to stop inappropriate usage of drugs, to implement the drug program of national necessity, to determine the drug usage in the proper way, and to organize the control properly.

According to the statistic report of 2002 through 2008, the rate of skin disease was ranked as 8 (4.5%) among common diseases, and as 7th (4.07%) among aimag level, but on the other hand the skin disease rate has increased by 59213 cases compared between 2002 and 2008.

Goal and Objectives. The main goal of the study was to determine the drug needs used in dermatological diseases where the results were compared with the current standard and to develop future recommendations to improve the proper usage of medicines.

Materials and Methods. In order to calculate the drug cost and demands, the main marketing methods were used such as calculation of past, current and future prognosis of drug demands. For example:

- The calculation of drug expenditure
- Calculation of drug demands by number of registered disease cases
- Development of the future prognosis of the disease based on the assessment of experts


Results. 1092 patients who were hospitalized in 2007 and 2008 in National Center of Dermatology, 464 patients who were hospitalized in the epidermis department of the general hospital of 12 provinces, totally 1725 patient's medical histories were chosen for drug usage in this research work. Average, patient day 12,7, males 867(50,3%) females 858(49,7%) children 283 (16,4%), adults 1442 (83,6%) participated in the research work. From all patients who are hospitalized are: patients who are in the hospital for the first time 1090 (63,2%), patients hospitalized for the second time 635 (36,8%). About patients who discharged from the hospital: 1055(61,2%) patients were recovered, and 670 (38,8%) patient's health conditions were improved. Here is the approved diagnosis in the frame of the research work: dermatitis 605 (35.1%), Psoriasis 355 (20.5%), eczema 266 (15.4%) is leading the list.

Discussion. According to research on the drug proper usage, each drug used for patients treatment was calculated upon the drug type, quantity, and patients percentage and it is concluded by its classification of analogical quantification. They are: Patient percentage who treated and recovered with preparations against Gistamin 62.8, Patient percentage who treated and recovered with antibiotics and preparations against bacterium 72.8, Patient percentage who treated and recovered with drugs of Corticosteroid group 87.4, Patient percentage who treated and recovered with viricide 16.9, Patient percentage who treated and recovered with antidote and sorbent 21, Patient percentage who treated and recovered with drugs promoting the body organs, organ system functions 81.7, Patient percentage who treated and recovered with Preparation for skin casting 51, Patient percentage who treated and recovered with disinfection preparations 45.

Key words: Drug usage, dermatological disease. Drug supplement, expenditure

Pp.58-61, Table1, Figures 4, References 14

ДЭМБ-ын мэдээгээр, сүүлийн жилүүдэд арьсны өвчлөл нэмэгдэж дэлхийд 5 хүн тутмын нэг нь арьс ба арьсан доорх эслэгийн өвчинеэр өвдөж байна [11]. Арьсны өвчин нь манай улсын хэмжээнд (2002-2008 он) сүүлийн 7 жилийн судалгаагаар нийт өвчлөл дотор өвчлөлийн тоогоор 4.5%-ийг эзлэж 8-р байранд байна [1.5.6]. Дэлхийн хүн ам жилд 2 % өсч, 33 жил дутамд 2 дахин нэмэгдэх төлөвлөтэй байгаа нь хэрэгцээ тэр дагуу өсөх болно [4]. Манай улсын хувьд ч арьсны өвчиний хүрээ ихсэж байгаа, нөгөө талаар дотоодын эмийн зах зээлдэх арьсны өвчлөлийн эмчилгээний эмийн эзлэх хувь бага зэрэг шалтгаанаас арьсны эмчилгээний эмийн жигд тогтвортой хангарт сайнгүй зэргээс үндэслэн судалгааны энэхүү сэдвийг сонгож авлаа. Арьсны өвчинеэр 2008-2009 онд эмнэлэгт хэвтсэн өвчтөнүүдээс энгийн санамсаргүй сонголтоор түүврийн нэгжийг сонгон авч, нийт 1725 өвчтний өвчиний түүхээс 209 нэрийн эм, 14 нэрийн эмнэлгийн жижиг хэрэгсэл бүгд 50.8 сая төгрөгийн үнийн дүнтэй эм бараа хэрэглэсэн байна.



Зураг 1. Монгол улсын хүн амын арьсны өвчлөлийн тархалт

Нэгдүгээр зургаас үзэхэд 2002 оны арьсны өвчлөлийн тохиолдлыг 2008 онтой харьцуулахад 2.8 дахин өссөн байна [8, 9].

Зорилго. Арьсны өвчиний стационарийн эмийн хэрэглээг бодит зарцуулалтаар болон өвчлөлөөр тооцон Монгол улсын 2005 оны “Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж”-тай харьцуулан дүгнэлт хийх [7]. Энэ зорилго хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно: Арьсны стационарын өвчиний эмийн зарцуулалтыг тооцох, туунд Монгол улсын 2005 оны “Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж”-ийн стандарттai харьцуулан судлаж, эмийн хэрэглээний прогноз гаргахын тулд:

1. Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолддог арьсны өвчиний эмчилгээний эмийн зарцуулалтанд судалгаа хийж эмийн хэрэглээ тоо үнийн дунг гаргах

2. Эмийн хангалтын судалгааг эмийн нэр төрлөөр хийх

Шинэлэг тал

Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолддог арьсны өвчиний эмүүдийн бодит хэрэглээг судлаж, улсын хэмжээнд стационарын эмчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн жижиг хэрэгслэлийн жилийн болон ойрын жилүүдийн хэрэгцээг бодит хэрэглээгээр нь, эмчилгээний стандарттай харьцуулж эмийн зохистой хэрэглээг баримтад тулгуурлан гаргасан хийгээд эмийн маркетингийн судалгааны арга аргачлал боловсруулсан нь судалгааны ажлын шинэлэг тал болж байна.

Судалгааны ажлын онол практикийн ач холбогдол

1. Өвчлөлийн тохиолдол болон эмийн бодит хэрэглээний зарцуулалтаар эмийн хэрэгцээг судалж, тухайн эмийн бүлгээр, эмийн нэр төрлөөр, арьсны өвчлөлд хэрэглэх эмчилгээний тохиолдлын хувьг гаргаж жилийн прогноз тогтоосон явдал нь эмийн хэрэглээг тооцох, арьсны эмийн төндөрийн захиалга үндэслэл сайтай оновчтой болох зэрэгт ач холбогдолоо өгөх болно.
2. Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг, арьсны өвчиний эмчилгээний хэрэгцээт эмээр шинжлэх ухааны үндэслэлтэй хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх суурь судалгааны үндэс болно.

Материал, арга зүй

2008 онд эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн арьсны өвчиний цочмог ба архаг хүнд, нэн хүнд хэлбэр гэсэн оноштой 0-86 хүртэл наасны, , (УБ хотоос 1261 өвчтөн, орон нутгаас 12 аймгийн 464) 1725 өвчтний өвчиний түүхээс баталгаажсан оношийн ангилал, стационарт хэрэглэсэн эмийн түүврийн судалгааг олон улсын эмийн хэрэглээний АТС ангиллын дагуу явуулав [14]. Эмийн хэрэгцээг тодорхойлох маркетингийн үндсэн аргууд, өнгөрсөн болон одоогийн эмийн хэрэглээтийн холбогдсон бодит түүврийг системчлэн цуглуулж эмийн хэрэгцээг тооцох, прогноз гаргахад дараах аргуудыг хэрэглэв. Энэ арга нь онолын хувьд (Retro retrospective) судалгаанд хамаарна. Судалгааны дунг статистикийн түгээмэл хэрэглэгдэх дундаж үзүүлэлт, үзүүлэлтийн алдааны хэлбэлзэл, судалгааны хүрээ ба хэмжээ зэргийг тодорхойлж, Стьюентийн шалгуураар үзүүлэлтийн магадлалыг шалгаж, комьюньюторийн Windows-Excel программыг ашиглан боловсруулалт хийв [2, 3]. Жилд эмчлэгдэх өвчтөний тоог өвчлөлийн хөдлөл зүйн тусламжтайгаар урьдчилан тооцож гаргасан нь тухайн жилд хэрэглэгдэх эмийн хэрэгцээг өвчлөлөөр тооцох нөхцөлийг бүрдүүллээ [2].

Хоногт хэрэглэх эмийн хэмжээ = Эмийн нэг удаагийн тун * Эмийг хоногт хэдэн удаа хэрэглэх

Эмчилгээний дундаж хэрэгцээ = Хоногт хэрэглэх эмийн хэмжээ * Эмчилгээний үргэлжлэх хугацаа

Зураг 2. Эмийн хэрэглээг бодит зарцуулалтаар тооцсон аргачлал

$$\begin{array}{l} \text{Tухайн өвчинд} \\ \text{шаардагдах эмийн} \\ \text{нийт хэрэгцээ} \end{array} = \begin{array}{l} \text{Эмчилгээний дундаж} \\ * \\ \text{хэрэгцээ} \end{array} \quad \begin{array}{l} \text{Өвчиний} \\ \text{тохиолдолын тоо} \\ * \end{array} = \begin{array}{l} \text{Tухайн эмээр} \\ \text{эмчлэгдэх өвчтөнийг} \\ \text{тооцох хувь} \end{array}$$

Зураг 3. Эмийн хэрэгцээг өвчлөлийн үзүүлэлтээр тооцсон аргачлал

Үр дүн, хэлцэмж

Нэг. Эмийн фармакологийн АТС ангиллын нэрсийн дагуу хангалтыг эмийн нэр төрлөөр гаргаж үзэхэд:

- Гистамины эсрэг эмийн бэлдмэл 37 эмийн нэр төрлөөс (12 эмийн нэр төрөл) 37 %-ийн хангалттай
- Кортикостероидууд давхардуулалгүйгээр 29 нэр төрлөөс (17 нэр төрлийн эм) 58%-ийн хангалттай байгаа зэрэг нь
- Эмийн нэр төрлийн сонголт хийх, ялангуяа сүүлийн үед арьсны өвчний эмчилгээний


практикт хэрэглэгдэж байгаа эмүүдийг монгол улсын эмийн бүртгэлд оруулах ажиллагаа дутмаг байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Хоёр. Эмийн хэрэглээг бодит зарцуулалтаар болон өвчлөлөөр тооцсон, эмийн хэрэгцээ ба прогнозыг тэргүүлэх ач холбогдол бүхий 45 нэрийн эмээр харуулахад, нийт эм барааны жилийн прогноз үнийн дунгээр 642.4 сая төг-ний хэрэгцээтэй нь тогтоогдов. Эмчилгээний хувиар тэргүүлэх 45 нэрийн эмийн үнийн дүн, нийт эмийн үнийн дунгийн 55.1%-г эзлэж байна. Эмчилгээний хувийг эмийн фармакологийн бүлгээр гаргасан судалгааны дүнтг хүснэгт 2-оор харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан эмийн эмчилгээний хувь (булгийн дунгээр)

№	Эмийн нэр тун хэмжээ	Тухайн булгийн эмээр эмчлэгдсэн өвчтний тоо	Тухайн булгийн эмээр эмчлэгдсэн өвчтний хувь
1	Гистамины эсрэг эмийн бэлдмэл	1083	62.8
2	Антибиотик ба нянгийн эсрэг бэлдмэл	1256	72.8
3	Кортикостериод	1508	87.4
4	Вирус эгэл биетний эсрэг эмийн бэлдмэл	292	16.9
5	Антидот сорбент	362	21
6	Эрхтэн системын эмчилгээний бэлдмэл	1409	81.7
7	Арьс гужуулах нөхөн төлжүүлэх эмийн бэлдмэл	880	51
8	Ариутгал халдвартгүйжүүлэх эмийн бэлдмэл	781	45.3
9	Эмнэлгийн жижиг хэрэгсэл		
	Үзлэгийн бээлий	1320	76.5
	Спирттэй хөвөн	1316	76.3
	Дуслын систем	1225	71
	Шприц н/у 3 гр	1397	81
	Шприц н/у 5 гр. 10 гр	776	45

Гурав. Судалгаанд хамрагдсан эмийн дотор импортын, эх орны үйлдвэрийн эмийн болон ҮЗШЭ-н эзлэх хувийн жинг тооцсон судалгааны дүнг 2-р зурагт үзүүллээ.



Зураг 4. Арьсны өвчлөлийн эмийн хэрэглээнд импортын болон эх орны эмийн эзлэх хувь

Судлагдсан нийт 223 нэрийн эм барааны дотор импортын эм 157(70.4%) нэр төрөл, эх орны үйлдвэрийн эм 66(29.6%) нэр төрөл байгаа нь дараах

дурслэлээр харагдаж байна. Манай улс өөрийнхөө эмийн хэрэглээний 33%-г эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангадаг гэсэн судалгааны дүнтэй харьцуулахад [13] 3.4-өөр дутуу гарч байна. Эмчилгээний стандарт нь ҮЗШЭ-ийг сонгосон байх ерөнхий зарчмитай боловч бодит амьдралд бүрэн хэрэгжих үндэслэл мутай байдгийн нэг жишээ нь судалгаанд хамрагдсан 209 нэр төрлийн эмийн бэлдмэлийн 103 (49.3%) нэрийн эмүүд ҮЗШЭ-ийн 2005 оны 5-р жагсаалтад багтсан эмүүд байна [10]. Арьсны өвчний эмэн эмчилгээний зарим эмүүдийг Монгол улсын эмийн бүртгэл, ҮЗШЭ, ЭМД-ын жороор үнийн хөнгөлөлттэй олгох эмийн жагсалтуудад шинээр оруулах эмийн нэрсийн санал зөвлөмж гаргасан нь ҮЗШЭ-ийн жагсаалтууд болон зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамжийг шинээр боловсруулахад үндэслэл болох боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт.

1. Арьсны өвчний эмчилгээнд: Гистамины эсрэг эмийн бэлдмэл нийт тохиолдлын 62,8%, антибиотик ба нянгийн эсрэг эмийн бэлдмэл 72.8 %, кортикостериод 87,4%, вирус эгэл биетний эсрэг эмийн бэлдмэл 16,9%, антидот ба сорбент 21%, эрхтэн системийн эмийн бэлдмэл 81,7 %, арьс гуужуулах нөхөн төлжүүлэх эмийн бэлдмэл 51%, ариутгал халдвартгүйжүүлэх эм 45,3%-д тус тус хэрэглэсэн нь тогтоогдоо.
2. Арьсны өвчний эмчилгээний эмийн хангалтыг нэр төрлөөр тооцоход: Гистамины эсрэг эмийн бэлдмэл 32.4 %, кортикостероидууд 58.6 %-ийн хангалттай байгаа нь эмийн нэр төрлийн сонголт хийх, ялангуяа сүүлийн үед арьсны өвчний эмчилгээний практикт хэрэглэгдэж байгаа эмийг монгол улсын эмийн бүртгэлд оруулах ажиллагаа дутмаг байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Ном зүй.

1. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн 2002-2008 оны Эрүүл мэндийн Статистик тайлан.
2. Мухар.Ц Монгол улсын хүн ам зүй, хүн амын эрүүл мэндийн байдал. Эрдмийн бичиг.УБ 2001 Х. 7-14
3. ДЭМБ. Номхон далайн баруун эргийн бүсийн төв. Эрүүл мэндийн судалгааны арга зүй. Хоёр дахь хэвлэл 2001 х.71-73,94

4. УСГ,”Монголын статистикийн эмхэтгэл 2007” УБ 2008
5. Эрүүл мэндийн үзүүлэлт 2007 он х.93,94
6. Эрүүл мэндийн үзүүлэлт 2008 он х.96,97
7. Эрүүл мэндийн яам, ДЭМБ, ЭМХҮТ. Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж. УБ 2005 он х.180-269
8. Эрдмийн чуулган -50. УБ 2008 он х.131-134
9. Эрдмийн чуулган -51. УБ 2009 он х. 8-10
10. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн тав дугаар жагсаалт УБ 2005 он
11. Мөнхбаярлах.С. “Бүх нийтээр ургамлын тоосны харшилаас сэргийльв” улсын зөвлөгөөний илтгэл х.9 УБ 2007 он
12. Цэрэнлхагва.Р. УБ 2002 он “Уушгины цочмог үрэвслийн эмчилгээний эмийн хэрэглээнд хийсэн маркетингийн судалгаа” Эм зүйн ухааны доктор ЭМШУИС х. 37, 39-40, 50.
13. Дамба.О. УБ 2004 он “ҮЗШЭ-ийн жагсаалтад орсон антибиотик эмийн хэрэглээнд хийсэн маркетингийн судалгаа” Эм зүйн ухааны доктор (Ph. D). ЭМШУИС х. 5, 29, 67. 95-96, 103, 105
14. Анатомо-тераевтическо-химическая классификация-Википедия 2009, с.1-3-14

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор Г.Чойжамц*